

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК  
аудитор: Я.Тунгалаг  
Утас: 99459698 Цахим хаяг: anu\_gantun@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ЗАВХАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН Б. БИЛГҮҮНДАЛАЙ ДАРГА  
ТАНАА

2023.02.24 № УВА-2023/172/НА-СТА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн яамнаас болон хандиваар 67,115.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 24,402.5 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200453

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>Дүгнэлтийн үндэслэл.....</b>	<b>3</b>
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно...	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг.....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>11</b>
<b>4.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>14</b>
<b>4.2 Материаллаг байдал .....</b>	<b>15</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	<b>15</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>16</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....</b>	<b>16</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>16</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>97,175,677.21</u></b>	<b><u>62,638,896.64</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	10,592,563.00	258,440.03
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	10,592,563.00	258,440.03
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	10,592,563.00	258,440.03
31213	Арилжааны банк дахь харилцах	10,592,563.00	258,440.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	59,487,825.20	3,081,987.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	62,187.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	57,142,100.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,345,725.20	3,019,800.00
3351	Байгууллагаас авах авлага	2,345,725.20	3,019,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	27,095,289.01	59,298,469.56
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	25,000.00	2,038,500.00
35130	Эм боох материал	25,000.00	2,038,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	27,070,289.01	57,259,969.56
35410	Бичиг хэргийн материал	1,687,100.00	1,687,100.00
35420	Аж ахуйн материал	4,786,176.50	10,717,826.50
35440	Түлш, шатах тослох материал	2,345,725.20	25.20
35460	Хүнсний материал	3,912,600.25	00.25
35470	Бусад хангамжийн материал	14,338,687.06	44,855,017.61
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>574,499,613.20</u></b>	<b><u>617,172,038.66</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	574,499,613.20	617,172,038.66
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	563,676,613.20	606,349,038.66
39201	сууц Барилга, байгууламж, орон	469,255,930.00	469,255,930.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,838,183.36	-54,390,023.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	120,480,000.00	165,470,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-53,084,666.64	-70,290,666.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,418,205.00	147,045,733.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,756,341.62	-68,237,859.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,104,207.00	32,004,207.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,992,537.18	-14,598,282.23
39217	Ном	90,000.00	90,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	10,823,000.00	10,823,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,823,000.00	10,823,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>671,675,290.41</u></b>	<b><u>679,810,935.30</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>671,675,290.41</u></b>	<b><u>679,810,935.30</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	671,675,290.41	679,810,935.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	553,058,316.72	553,058,316.72
51101	Өмч: - төрийн	553,058,316.72	553,058,316.72
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	52,860,371.58	60,996,016.47
51210	Өмнөх үеийн үр дүн	52,860,371.58	52,860,371.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	8,135,644.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,756,602.11	65,756,602.11

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	671,675,290.41	679,810,935.30
---	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>712,745,574.76</b>	<b>676,318,361.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>101,670,374.76</b>	<b>105,801,921.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	82,980,384.76	105,801,921.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,980,384.76	10,592,563.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	10,592,563.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,980,384.76	00.00
120009	Бусад орлого	00.00	4,085,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	18,689,990.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	18,689,990.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>205,216,900.00</b>	<b>570,516,440.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,858,300.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	119,185,800.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,185,800.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,889,000.00	31,639,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,889,000.00	31,639,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	57,142,100.00	538,877,040.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	57,142,100.00	538,877,040.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>584,761,162.07</b>	<b>668,182,716.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>584,761,162.07</b>	<b>668,182,716.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	562,257,182.07	581,819,682.66
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	329,489,306.00	320,408,105.00
210101	Үндсэн цалин	293,424,524.00	233,159,439.00
210102	Нэмэгдэл	00.00	53,765,298.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,658,000.00	4,700,000.00
210104	Урамшуулал	26,366,782.00	23,743,368.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,977,931.00	40,337,076.92
210201	Тэтгэврийн даатгал	29,754,373.24	27,900,642.39
210202	Тэтгэмжийн даатгал	3,332,388.26	3,289,743.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,581,910.82	2,574,674.65
210204	Ажилгүйдлийн даатгал	560,770.58	597,455.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,748,488.10	5,974,560.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,625,020.00	29,761,029.00
210301	Гэрэл, цахилгаан	1,696,020.00	2,721,629.00
210302	Түлш, халаалт	22,789,000.00	25,539,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,140,000.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,994,129.60	50,263,544.20
210401	Бичиг хэрэг	1,598,100.00	4,009,290.00
210402	Тээвэр, шатахуун	20,194,029.60	35,921,504.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,618,000.00	1,651,450.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	4,526,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,384,000.00	4,154,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>73,789,690.00</b>	<b>68,534,875.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,030,050.00	55,628,275.00
210502	Хоол, хүнс	12,259,640.00	12,344,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	562,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,542,300.00</b>	<b>16,219,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,533,500.00	1,196,000.00
210602	Тавилга	00.00	100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,110,000.00	7,470,000.00
210604	Урсгал засвар	4,898,800.00	7,453,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>358,000.00</b>	<b>1,274,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	358,000.00	1,274,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,390,000.00</b>	<b>3,752,550.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	2,208,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	333,460.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	565,000.00	710,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	52,690.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,090,805.47</b>	<b>51,269,002.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,419,000.00	2,423,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,671,805.47	48,845,102.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,503,980.00</b>	<b>86,363,034.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>56,692,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,400,000.00</b>	<b>19,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,400,000.00	19,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,103,980.00</b>	<b>78,371.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>10,592,563.00</b>
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	10,592,563.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>127,984,412.69</b>	<b>8,135,644.89</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>572,623,090.00</b>	<b>585,644,003.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,689,990.00</b>	<b>14,677,563.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	14,677,563.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	10,592,563.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	10,592,563.00

/төгрөг/

120009	Бусад орлого	00.00	4,085,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	18,689,990.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	18,689,990.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>553,933,100.00</b>	<b>570,966,440.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	405,858,300.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	119,185,800.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	119,185,800.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,889,000.00	31,639,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,889,000.00	31,639,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	539,327,040.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	539,327,040.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>562,030,527.00</b>	<b>571,575,625.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>562,030,527.00</b>	<b>571,575,625.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>531,126,547.00</b>	<b>541,904,691.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	320,945,501.00	320,408,105.00
210101	Үндсэн цалин	284,880,719.00	233,159,439.00
210102	Нэмэгдэл	00.00	53,765,298.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,658,000.00	4,700,000.00
210104	Урамшуулал	26,366,782.00	23,743,368.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,121,736.00	40,399,263.97
210201	Тэтгэврийн даатгал	29,898,178.24	27,962,829.44
210202	Тэтгэмжийн даатгал	3,332,388.26	3,289,743.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,581,910.82	2,574,674.65
210204	Ажилгүйдлийн даатгал	573,566.58	597,455.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,735,692.10	5,974,560.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,985,020.00	29,761,029.00
210301	Гэрэл, цахилгаан	1,696,020.00	2,721,629.00
210302	Түлш, халаалт	22,789,000.00	25,539,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,262,200.00	52,373,069.00
210401	Бичиг хэрэг	1,598,100.00	3,949,290.00
210402	Тээвэр, шатахуун	23,106,100.00	34,249,879.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,618,000.00	1,651,450.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	7,000,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,640,000.00	5,492,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	76,027,890.00	70,449,275.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,067,250.00	57,518,275.00
210502	Хоол, хүнс	15,222,240.00	8,431,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,738,400.00	4,499,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,658,800.00	18,247,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,750,000.00	1,997,500.00
210602	Тавилга	00.00	100,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,010,000.00	8,500,000.00

210604	Урсгал засвар	4,898,800.00	7,650,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	358,000.00	1,274,000.00
210702	Дотоод албан томилолт	358,000.00	1,274,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,390,000.00	4,492,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	2,858,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	333,460.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	94,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	565,000.00	800,000.00
210807	Газрын төлбөр	40,000.00	52,690.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,377,400.00	4,499,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,377,400.00	4,499,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,903,980.00</b>	<b>29,670,934.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,800,000.00	19,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,800,000.00	19,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,103,980.00	78,371.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	10,592,563.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	10,592,563.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>10,592,563.00</b>	<b>14,068,377.03</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>24,402,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>24,402,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	24,402,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	24,402,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-24,402,500.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	10,592,563.00	-10,334,122.97
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	10,592,563.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	10,592,563.00	258,440.03

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтл агдсан дүн	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,235,316.72	40,100,796.09	80,031,357.32	502,304,755.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,134.80	7,134.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542,235,316.72	40,100,796.09	80,024,222.52	502,311,890.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	10,823,000.00	00.00	6,446,361.46	17,269,361.46
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>553,058,316.72</b>	<b>65,756,602.11</b>	<b>52,860,371.58</b>	671,675,290.41
D01	<b>2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>553,058,316.72</b>	<b>65,756,602.11</b>	<b>52,860,371.58</b>	671,675,290.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>553,058,316.72</b>	<b>65,756,602.11</b>	<b>52,860,371.58</b>	671,675,290.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,135,644.89	8,135,644.89
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>553,058,316.72</b>	<b>65,756,602.11</b>	<b>60,996,016.47</b>	679,810,935.30

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /улсын төсөв/

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>10592563.00</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	586,176,800.00	553,296,162.97	34,383,037.0	94.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	567,176,800.00	534,296,162.97	34,383,037.0	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,713,600.00	<b>320,408,105.00</b>	29,305,495.0	91.6
210101	Үндсэн цалин	307,400,000.00	233,159,439.00	74,240,561.0	75.8
210102	Нэмэгдэл	00.00	53,765,298.00	-53,765,298.0	#DIV/0!
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	4,700,000.00	1,108,000.0	80.9
210104	Урамшуулал	31,465,600.00	23,743,368.00	7,722,232.0	75.5
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	5,040,000.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,714,100.00	<b>40,399,263.97</b>	3,314,836.0	92.4
210201	Тэтгэврийн даатгал	29,725,600.00	27,962,829.44	1,762,770.6	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,497,100.00	3,289,743.37	207,356.6	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,797,700.00	2,574,674.65	223,025.4	92.0
210204	Ажилгүйдлийн даатгал	699,400.00	597,455.90	101,944.1	85.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,994,300.00	5,974,560.61	1,019,739.4	85.4

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53,429,500.00	<b>52,373,069.00</b>	1,056,431.0	98.0
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,949,290.00	50,710.0	98.7
210402	Тээвэр, шатахуун	34,250,000.00	34,249,879.00	121.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,585,000.00	1,651,450.00	933,550.0	63.9
210404	Ном, хэвлэл	100,000.00	30,000.00	70,000.0	30.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,002,400.00	7,000,350.00	2,050.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,492,100.00	5,492,100.00	0.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	70,523,600.00	<b>70,449,275.00</b>	74,325.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,523,600.00	57,518,275.00	5,325.0	100.0
210502	Хоол, хүнс	8,500,000.00	8,431,500.00	68,500.0	99.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	4,499,500.00	500.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	40,850,000.00	<b>40,850,000.00</b>	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,500,000.00	18,500,000.00	0.0	100.0
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	0.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,500,000.00	8,500,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	5,850,000.00	5,850,000.00	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,665,000.00	1,274,000.00	391,000.0	76.5
210702	Дотоод албан томилолт	1,665,000.00	1,274,000.00	391,000.0	76.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,283,400.00	4,042,550.00	240,850.0	94.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,408,400.00	2,408,400.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	288,000.00	72,000.0	80.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	333,460.00	66,540.0	83.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,000.00	94,000.00	66,000.0	58.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	66,000.00	34,000.0	66.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	800,000.00	0.0	100.0
210807	Газрын төлбөр	55,000.00	52,690.00	2,310.0	95.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4500000.00</b>	<b>4499900.00</b>	100.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,499,900.00	100.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19000000.00</b>	<b>19000000.00</b>	0.0	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	19,000,000.00	19,000,000.00	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,000,000.00	19,000,000.00	0.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	586,176,800.00	542,962,040.0	31,810,320.0	94.8
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	71,369,700.0	4,085,000.00	0.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	71,369,700.0	4,085,000.00	0.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	514,807,100.0	538,877,040.0	74,042,283.0	87.9
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	514,807,100.0	538,877,040.0	74,042,283.0	87.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	10,592,563.00	-10,592,563.0	0.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	10,592,563.00	-10,592,563.0	0.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	10,592,563.00	-10,592,563.0	0.0

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	258,440.03	-258,440.0	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.0	100.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
21	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	99.75
210	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	99.75
2103	Бараа, үйлчилгээний зардал	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	99.75
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,839,400.0	29,761,029.0	78,371.00	99.74
210302	Гэрэл цахилгаан	2,800,000.0	2,721,629.0	78,371.00	97.20
210303	Түлш, халаалт	25,539,400.0	25,539,400.0	-	100.00
2106	Цэвэр, бохир ус	1,500,000.0	1,500,000.0	-	100.00
210604	Эд хогшил худалдан авах	1,800,000.0	1,800,000.0	-	100.00
	Урсгал засвар	1,800,000.0	1,800,000.0	-	100.00
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	-
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	-
4	Орон нутгийн төсвөөс	31,639,400.0	31,561,029.0	78,371.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

## 2.6 Аудит хийгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөг/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>			<b>450,000.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>			<b>450,000.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>			450,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>			450,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			450,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		0.00	450,000.00
Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих			450,000.00

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, өвчлөл эндэгдэлийг бууруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль - 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль-2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,017.7 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,592.50	258.40	-10,334.10
Авлага	59,487.80	3,081.90	-56,405.90
Бараа материал	27,095.30	59,298.50	32,203.20
Үндсэн хөрөнгө	574,499.60	617,172.00	42,672.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>671,675.30</b>	<b>679,810.90</b>	8,135.60
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	671,675.30	679,810.90	8,135.60
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>671,675.30</b>	<b>679,810.90</b>	8,135.60

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 10,334.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 3,081.9 мянган төгрөг болж буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,298.5 мянган төгрөг болж 32,203.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 617,172.0 мянган төгрөг болж 42,672.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 24,402.5 мянга, ЭМЯ-наас болон хандиваар 67,115.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 679,810.9 мянган төгрөг болж 8,135.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 589,679.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Хүргүүлсэн төсвийн төслөөр баталсан боловч, анх батлагдсан төсвөөс тодотгол хийгдэж 12,516,0 мянган төгрөгөөр бууруулан 553,296,1 мянган төгрөг баталсан. Энэ нь ханиад томууны өвчлөлөөс шалтгаалан, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу авсанаас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр,ф 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 574,601.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 31,639.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, бусад орлого 4,085.0 мянга 538,877.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 538,877.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 31,639.4 мянган төгрөг, бусад орлого 4,085.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 584,857.2 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 258.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн 78.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс	586,176.8	553,296.1	32,880.6	94.3%
	Орон нутгийн төсвөөс	31,639.4	31,561.1	78.3	88.0%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,857.2 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 29,305.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,314.8 мянга, хангамж, бараа материалын зардлыг 1,056.4 мянга, норматив зардлыг 74.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсан байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт 57,142.1 мянган төгрөгийг бүрэн авсантай холбоотой байна.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Завхан сумын Эрүүл

мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар 7,974.1 мянган төгрөгийн зарлага гараагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Завхан сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК - д 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 629.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 777.2 сая төгрөгийн 1 хувь 7.7 сая төгрөгөөс 80 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Завхан сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,



**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“УВС ФИНАНС АУДИТ” ХХК-ийн  
АУДИТОР

 /С.ЦЭРЭНМИНЖИН/

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр